ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/20/-НА-СТА-ТТЗ

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

№ _____

танай _____ -ны № _____ -т

ГУУЛИН ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Б.АМАРТҮВШИН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар орон нутгийн орлого тасарсан, илүү, дутуу санхүүжилт олгосон, малын тоо, толгойн албан татварын орлогыг ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн хөрөнгө, өр төлбөрийн эхний үлдэгдэл шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 90 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

07020308

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	169,076.71	41,266.43
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,517,467.28	298,009.90
	Нийт хөрөнгийн дүн	**1,686,543.99**	**339,276.33**
	Нийт өр төлбөрийн дүн	22,133.51	1,637.23
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,664,410.48	337,639.10
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**1,686,543.99**	**339,276.33**
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	530,943.79	530,943.79
	Үйл ажиллагааны зардлын дүн	329,599.01	329,599.01
	Үйл ажиллагааны үр дүн	**201,344.79**	**201,344.79**
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	**201,344.79**	**201,344.79**
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,640,325.28	1,620,967.04
	Тайлант оны үр дүн	24,085.20	-1,283,327.93
	Эцсийн үлдэгдэл	**1,664,410.48**	**337,639.10**
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	298,066.19	298,066.19
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		
	Үйл ажиллагааны ЦМГ	298,066.19	298,066.19
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	302,918,219.64	302,918,219.64
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(302,620.15)	(302,620.15)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,070.57	44,070.57
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,218.53	39,218.53
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**300,022.80**	**283,547.33**
	Урсгал зардал	300,022.80	283,547.33
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	**300,022.80**	**283,547.33**
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,022.80	283,547.33
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	-

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гурав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар алдаа зөрчил илэрсэнгүй.

Нэгж байгууллагуудын аудитаар 3.0 сая төгрөгийн алдаа илэрч залруулсан байна.

Нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:
Төвлөрүүлэн захирагчийн харьяа нэгж, байгууллагуудад нийт 11.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 2.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 15.1 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс 14.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 3 заалт албан шаардлага, 1.0 сая төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

- ✓ Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд хөрөнгийн орлого 0.8 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.1 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 0.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.05 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 0.2 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Дэлгэр сумын сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төсөвт байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо батлагдсан төсвөөс 6.2 сая төгрөгийн санхүүжилт илүү, 1.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн өрөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Дэлгэр сумын сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Малын тоо, толгойн албан татварын орлого 4.4 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

1. Хууль тогтоомжтой холбоотой

- ✓ Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийн дүн Сангийн яаманд хянагдсан төсвөөс 1.0 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх"; 22 дугаар зүйлийн 22.6.4-т "төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар баталсан төсвөө Сангийн яаманд хянуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 7 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн
ТТЗ	-	-										
Захирагчийн алба	3	0.00	3	0.00	-	-	3	3.00				
Дүн	**3**	**0.00**	**3**	**0.00**	**-**	**-**	**3**	**3.00**	**-**	**-**	**-**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Албан тушаалтны too	Too	Дүн
ТТЗ	3	13.40			2	12.40	1	1.00				
Захирагчийн алба	5	11.96	3	9.96	2	2.00						
Дүн	**8**	**11.96**	**3**	**9.96**	**2**	**2.00**	**-**	**-**	**-**	**-**	**-**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ								
Захирагчийн алба	2	-			1		1	
Дүн	**2**	**-**		**-**	**1**	**-**	**1**	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	1	1.70			1	1.70		
Захирагчийн алба	1	-					1	
Дүн	**2**	**1.70**		**-**	**1**	**1.70**	**1**	
Нийт дүн	**4**	**1.70**		**-**	**2**	**1.70**	**2**	

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	3	2		2	1		
2	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	**9**	**4**	**5**		**3**	**1**		

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР